

## Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

Далай тауэр 9 давхар, ЮНЕСКО  
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р  
хороо, Улаанбаатар 14230,  
Монгол улс  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

Dalai Tower, 9 fl, UNESCO street,  
Sukhbaatar District-1, Ulaanbaatar  
14230, Mongolia  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

### **“Бодь даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:**

#### **Хязгаарлалттай дүгнэлт**

Бид “Бодь даатгал” ХК (цаашид “компани” гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид “хураангуй санхүүгийн тайлан” гэх) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү Хураангуй санхүүгийн тайлан нь тодруулгад тайлбарласны дагуу бүхий л материаллаг зүйлсийн хүрээнд аудит хийгдсэн тайлантай нийцэж байна.

#### **Хураангуй санхүүгийн тайлан**

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Сангийн сайдын 132 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-аар шаардсан бүх тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул “Бодь даатгал” ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

#### **Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт**


Бид аудитлагдсан санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Учир нь компанийн нөөц сангийн тооцоололд ашигласан дата мэдээлэл үнэн зөв эсэхэд хангалттай бөгөөд зохистой баримт нотолгоо олж чадаагүй.

#### **Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага**

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн 2020 оны 7 дугаар сарын 7-ний өдрийн Сангийн сайдын 132 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

#### **Аудиторын үүрэг хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын Олон Улсын Стандарт, Монгол Улсын “Аудитын тухай” хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.



# Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2020	2019
<b>Хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	366,741	749,531
Даатгалын авлага	3,530,741	6,203,218
Бусад санхүүгийн хөрөнгө	3,657,459	3,018,655
Бусад санхүүгийн бус хөрөнгө	1,120,764	952,296
Хөрөнгө оруулалт	13,767,141	9,261,546
Даатгалын хөрөнгө	8,702,042	10,657,657
Үндсэн хөрөнгө, цэвэр	1,416,556	1,798,434
Биет бус хөрөнгө, цэвэр	113,589	133,756
<b>Нийт хөрөнгө</b>	<b>32,675,033</b>	<b>32,775,093</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>Өр төлбөр</b>		
Даатгалын өглөг	896,208	4,844,543
Бусад санхүүгийн өр төлбөр	786,822	649,391
Бусад санхүүгийн бус өр төлбөр	723,860	738,245
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	13,314,770	15,324,545
Нөхөн төлбөрийн нөөц сан	3,391,792	2,766,170
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>19,113,452</b>	<b>24,322,894</b>
<b>Эздийн өмч</b>		
Хувийн өмч	5,882,975	5,000,544
Нэмж төлөгдсөн капитал	2,193,309	0
Дахин үнэлгээний нэмэгдэл	304,850	519,555
Хуримтлагдсан ашиг	5,180,447	2,932,100
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>13,561,581</b>	<b>8,452,199</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>32,675,033</b>	<b>32,775,093</b>

# Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2020	2019
Даатгалын хураамжийн нийт орлого	33,816,919	27,945,685
Даатгалын хураамжийн буцаалт	611,126	893,154
Давхар даатгалын хураамжийн зардал	18,537,396	13,020,506
<b>Даатгалын хураамжийн цэвэр орлого</b>	<b>14,668,397</b>	<b>14,032,025</b>
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	2,009,774	7,573,410
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	(1,918,136)	(9,167,993)
<b>Орлогод тооцсон хураамж</b>	<b>14,760,035</b>	<b>12,437,442</b>
Нийт нөхөн төлбөрийн зардал	8,583,286	8,094,605
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	(2,039,226)	(2,045,291)
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	(515,542)	(580,372)
<b>Нөхөн төлбөрийн цэвэр зардал</b>	<b>6,028,517</b>	<b>5,468,942</b>
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	401,347	(866,936)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	9,785	42,717
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	224,275	150,183
<b>Зардалд тооцсон нөхөн төлбөр</b>	<b>6,663,925</b>	<b>4,794,906</b>
Даатгалын гэрээний зардал	(2,150,633)	(1,927,914)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	1,158,456	895,731
Хөрөнгө оруулалтын орлого	1,524,927	1,072,530
<b>Даатгалын үйл ажиллагааны ашиг</b>	<b>8,628,859</b>	<b>7,682,882</b>
Ерөнхий ба удирдлагын зардал, Борлуулалт, маркетингийн зардал	(6,498,657)	(5,619,120)
Бусад орлого/ (зардал)	198,898	(156,322)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>2,329,100</b>	<b>1,907,440</b>
Орлогын татварын зардал	(257,880)	(217,519)
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>2,071,220</b>	<b>1,689,921</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>0.009</b>	<b>0.008</b>

Тодруулга: Бодь даатгал ХК-ийн энэхүү хураангуй санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартад нийцүүлэн 2020 оны 7 дугаар сарын 7-ний өдрийн Сангийн сайдын 132 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон орлогын дэлгэрэнгүй тайлангаас ямар нэгэн зөрүүгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.